



**НИЙСЛЭЛИЙН СОЁЛЫН ТӨВ ӨРГӨӨНИЙ  
2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

УЛААНБААТАР ХОТ

2022 ОН

**Гарчиг**

1. Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүн .....3
2. Тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, үр дүн ..... 3-9
3. Байгууллагын үйл ажиллагааны үр дүн ..... 10-51
4. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал ..... 51-56
5. Цаг үеийн шаардлагаар хийсэн ажлын үр дүн ..... 56-69

## СОЁЛЫН ТӨВ ӨРГӨӨНИЙ 2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

### **Нэг: Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилт.**

**Өргөө нь** Монгол Улсын хууль, Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 хөтөлбөр, Улсын Их Хурлаас 2012 онд баталсан “Төрөөс соёлын талаар баримтлах бодлого, Засгийн Газраас батлагдсан төсөл хөтөлбөр, Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан “Нийслэлийн хүн амд үзүүлэх соёл, урлагийн үйлчилгээний нэр төрлийг олшруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх, соёл урлагийн гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх” зорилтууд, байгууллагын үйл ажиллагаанд мөрдөхөөр батлагдсан дүрэм, журам, зааврыг хэрэгжүүлж ирлээ. Тухайлбал:

- Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулиар төрийн үйлчилгээний албанд тавигддаг зарчим, шаардлага болон холбогдох заалтууд, нийслэлийн өмчийн эд хөрөнгийг бэлтгэх, бүртгэх, ашиглах, хамгаалах, түрээслэхэд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Архивын тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, НИТХ-ын тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж ирлээ.
- “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичигт тусгасан зорилт, арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэх, нийслэлийн хүн ам, нийгэм, эдийн засгийн хөгжил, байгаль орчны тэнцвэртэй байдал, засаглалыг сайжруулахад чиглэсэн нэгдмэл цогц, харилцан уялдаатай, давхардалгүй, хүртээмжтэй, бүх нийтийн оролцоог хангасан байх зарчмуудыг баримтлан “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр” төлөвлөлтийн баримт бичигт дэвшүүлсэн зорилтыг байгууллагынхаа үйл ажиллагаанд хэрэгжүүлж ажиллаж байна.

### **Хоёр: Тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, үр дүн**

#### **2.1. Байгууллагын үйл ажиллагааг тайлагнах хугацаа**

Байгууллагын үйл ажиллагааны тайланг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журам”-ын хавсралтын дагуу бодлогын баримт бичиг, захирамжлалын баримт бичгийн хэрэгжилтийг хагас, бүтэн жилийн байдлаар гаргаж, холбогдох материалын хамт НЗДТГ-ын Хяналт Шинжилгээ Үнэлгээний хэлтэст хүргүүлж хэвшсэн болно.

## 2.2. Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилт.

Засгийн газраас 2018 онд баталсан “Төрийн албаны сахилга, хариуцлага, дэг журмыг чангатгах” 258 тогтоол, Нийслэлээс 2022 оныг “Хотын иргэний жил” болгож, 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”, Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасны хугацааны нэмэгдэл олгох журам”, “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам”, “Төрийн үйлчилгээний албан хаагчид мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох нийтлэг журам”, Төрийн албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”-уудын хэрэгжилтийг хангаж, ажиллагаандаа хэвшил болгон ажиллаж ирлээ. Үүнд:

1. Төрийн албаны тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-ын хэрэгжилтийг хангаж, 2022 онд өндөр насны тэтгэвэрт гарах 2 албан хаагчид IV улиралд **25,511,200** төгрөгийг, гачигдлын улмаас 4 албан хаагчдын ар гэрт нь **2,000,000** төгрөг, буцалтгүй тусламжид **4,857,814**, Эх үрсийн баярын өдөр нийт ажилтнуудын хүүхдүүдэд **1,429,000** төгрөгийг бэлгэнд зарцуулж нийт **35,511,200** төгрөгийг жилд олгохоор төлөвлөснөөс **33,798,014** төгрөгийг 2022 онд олгож ажиллалаа.
2. Хөдөлмөрийн тухай хуулийг хэрэгжүүлж, байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, Хөдөлмөрийн гэрээ шинэчлэн баталгаажуулж, үйл ажиллагаандаа мөрдөж байна.
3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, Эрүүл ахуйн тухай хууль, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын холбогдох заалтуудыг үндэслэн Соёлын Төв Өргөөний “Албан хаагчдын дагаж мөрдөх хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм”, албаны “Албан хаагчдын дагаж мөрдөх хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны журам”-ыг баталж, хэрэгжүүлж хэвшлээ.
4. “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай”-ийн дагуу Захирал, ахлах нягтлан бодогч нар хувийн ашиг сонирхолын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг хуулийн дагуу гаргадаг.
5. Шилэн дансны хуулийн дагуу 2022 онд холбогдох санхүүгийн мэдээллүүдийг цаг хугацаанд нь шилэн дансны нэгдсэн системд оруулж ажиллалаа. Шилэн дансны нэгдсэн системд байгууллагын батлагдсан төсөв сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого зарлагын гүйлгээ зэрэг багтаж байгаа юм.

Мөн шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээ, мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцан ажиллаж, тайланг цаг тухайд нь Сангийн яаманд илгээж байна. 2022 оны

жилийн эцсийн байдлаар нийт 151 шилэн дансны мэдээлэл оруулахаа 151 мэдээллийг цаг хугацаанд нь байршуулж ажиллалаа. 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хөндлөнгийн аудитыг Нийслэл дэх Төрийн аудитын газраар хийлгэж, **“Санхүүгийн тайлангаа холбогдох хууль, санхүүгийн тайлангийн олон улсын стандарт, нягтлан болох бүртгэлийн олон улсын стандарт, түүнд нийцүүлсэн холбогдох заавар журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн, санхүүгийн зөрчилгүй”** гэсэн дүгнэлт авсан.


6. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхлэхтэй холбогдуулан цаг бүртгэлийн төхөөрөмжид хадгалагдаж байсан 79 албан хаагчдын биеийн давхцахгүй өгөгдөл (гарын хурууны хээ)-ийг устган, серверийг форматалж хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллалаа.
7. Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн хэрэгжилтийг ханган ажиллаж, холбогдох заалтыг байгууллагын дотоод журамд тусгаж хэрэгжүүлж байна. Мөн Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн 1.2 дахь заалтыг үндэслэн байгууллагын чиг үүрэг, үйлчилгээний онцлогийг харгалзан албан хаагчдын ёс зүйн дүрмийг боловсруулан гаргаж, мөрдөж байна.
8. Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр дэх Цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулна (1.1.1), Хотын соёлыг төлөвшүүлж түгээн дэлгэрүүлэх ажлыг бүх шатанд зохион байгуулна (2.6.3) гэсэн зорилтуудыг хэрэгжүүлж ирлээ. Хэрэгжилтийг тайлангийн (3.1.2) хэсэгт дэлгэрэнгүй тусгасан болно.
9. Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр дэх /1.1.1/ “Цар тах лаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулна” гэсэн зорилтынхүрээнд дараах ажлуудыг хийж хэрэгжүүллээ.

Манай байгууллага нь хорио цээрийн дэглэм сулраагүй үеэр Улсын Онцгой комисс, Нийслэлийн Онцгой комисс болон Монгол Улсын Соёлын сайдын тушаалуудыг тус тус баримтлан халдвар хамгааллын дэглэмийг сахиж, нэг чигийн урсгалаар хөдөлгөөнийг давхцуулахгүй байдлаар үзэгчдийн хаалганд орох, гарах хөдөлгөөнийг зохицуулах хариуцлагатай жижүүрийг томилон, үзэгч үйлчлүүлэгчдийн халууныг хэмжих багаж хэрэгслийг байршуулж, QR код уншуулах, амны хаалт зүүх, гарыг халдваргүйжүүлэх шаардлага тавьж ажиллалаа.



Тоглолт арга хэмжээг зохион байгуулагч байгууллагад үзвэрийн тасалбарыг цахимаар борлуулах шаардлага тавьж, халдвар хамгааллын дэглэмийг сахин тоглолт арга хэмжээг зохион байгуулж ажиллах үүрэг өгч хэрэгжилтэд хяналт тавьж ажиллалаа. Үүнд:

- Хотын соёлыг түгээн дэлгэрүүлэх, үзэгчдийн үзвэр үзэх соёлыг дээшлүүлэх зорилгоор үзвэр, хурал арга хэмжээ эхлэхийн аудио санамж бичлэгийг үзэгч үйлчлүүлэгчдэд тогтмол хүргэн ажиллаж байна.
  - Үзвэрийн танхимд ус ундаа, хүнсний бүтээгдэхүүн хэрэглэхийг хориглосон санамжуудыг байршууллаа.
  - Тоглолт арга хэмжээний үед тайзны тоног төхөөрөмжийг ариутгалын бодисоор тогтмол цэвэрлэж, микрофоныг нэг удаагийн бүрхэвч уутаар хамгаалж, халдвар хамгааллын дэглэмийг сахиж ажиллалаа.
  - Их танхимд үзвэрийн өмнө ба дараа агаар сэлгэлт тогтмол хийж, цэвэрлэгээ үйлчилгээг халдваргүйжүүлэх бодис уусмал ашиглан халдвар хамгааллын дэглэмийг сахин чанартай гүйцэтгэлээ.
- Ковид-19 цар тахлаас сэргийлэх, халдварын сэжигтэй тохиолдол илэрсэн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээ, ажиллах комиссын бүрэлдэхүүнийг томилж, байгууллагын “А” болон “Г” зонд “**Түр тусгаарлах өрөө**”-г гаргаж шаардлагатай тоног төхөөрөмж, ариун цэвэр эрүүл ахуйн хэрэгслүүдээр ханган бэлэн байдалд ажилласан. Түр тусгаарлах өрөөнд ор, ширээ сандал, ус буцалгагч, нэг удаагийн аяга, гарын цаасан алчуур, 00 цаас, гарын шингэн саван, гар халдваргүйжүүлэх уусмал, зэргээр хангаж ажиллалаа.
  - Нийслэлийн Засаг даргын тамгын газраас ирсэн зөвлөмжийн дагуу цар тахлаас сэргийлэх зорилгоор ажлын байранд гадны хүн нэвтрүүлэхгүй, шаардлагатай тохиолдолд холбогдох албан тушаалтныг дуудаж үйлчлүүлэх, хүлээн авч “Уулзах цэг”-ийг “А” байрны 101 тоот өрөөнд, “Г” байрны урд хэсэгт гаргаж, тохижуулан ажиллалаа.



Уулзалтын хэсэг Г байранд:



Уулзалтын хэсэг А байранд:





- UB ERP-EDoc системийг ашиглан цахим тоон гарын үсгээр албан бичгүүдээ илгээж, хүлээн авч хэрэгжилтийг ханган ажиллаж байна.
- Нийслэлийн Соёлын Төв Өргөө нь Ковид-19 /коронавируст/ халдварын хорио цээрийн дэглэмийн үед цар тахлаас урьдчилан сэргийлж тархалт хүрээг нь нэмэгдүүлэхгүйн тулд байгууллагын хэмжээнд жилийн эцсийн байдлаар ариутгал халдваргүйжүүлэлт хийлгэх ажлыг нийт 6 удаа зохион байгуулж, ажиллалаа.





- “А” болон “Г” байрны үйлчилгээний ажиллагсад өөрсдийн хариуцсан талбайдаа өдөр тутмын цэвэрлэгээ үйлчилгээг зориулалтын ариутгалын бодисоор хийхээс гадна үзэгчдийн их танхимын хивсэнцэр, 3-р давхрын фойейны хивсэнцэрийн өнгөлгөө, “А”, “Г” байрны подвалд бүх нийтийн их цэвэрлэгээг 14 хоногт 1 удаа тогтмол хийж, өрөө тасалгаа, шат, хаалганы бариул зэрэг хүн их хүрдэг хэсгүүдийг ариутгалын бодистой уусмалаар арчиж, цэвэрлэж хэвшлээ.



**Гурав. Байгууллагын үйл ажиллагааны үр дүн:**

**3.1. Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр дэх /2.6.3/ “Хотын соёлыг төлөвшүүлж түгээн дэлгэрүүлэх ажлыг бүх шатанд зохион байгуулна” гэсэн зорилт, байгууллагын дүрмээр хүлээсэн “Хүн амд үзүүлэх соёл урлагийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх” үүргийн хүрээнд хийсэн ажил, үр дүн.**

Өргөө нь байгууллагын дүрмээр хүлээсэн “Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан соёл урлагийн бодлого зорилтыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлж, “Нийслэлийн хүн амд соёл урлагаар үйлчлэх үйлчилгээний нэр төрлийг олшруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх” үүргийн хүрээнд үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу ажлаа хэрэгжүүлж эхэллээ. Тухайлбал:

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны тэмдэглэлээр Урлаг, соёл, спортын арга хэмжээг 50 хувийн дүүргэлттэйгээр зохион байгуулах ажлын хүрээнд Дэлхий дахинд тархсан Коронавируст халдвар /COVID-19/-аас урьдчилан сэргийлэх чиглэлээр Монгол Улсын Засгийн газар, Улсын Онцгой комисс, Эрүүл мэндийн яам, бусад мэргэжлийн байгууллагуудаас гаргасан тогтоол, захирамж, тушаал, заавар, журмын хэрэгжилтийг ханган халдвар хамгаалалтын дэглэмийг сахиулж, шаардагдах материалын нөөцийг бүрдүүлэн Соёл урлагийн арга хэмжээнд тавигдах тусгай нөхцөл шаардлага, стандартуудыг мөрдөж өдөр тутмын захиалгат арга хэмжээ, тоглолт, хурлын үйл ажиллагаанд дээрх дүрэм журмыг байгууллагын үйл ажиллагаанд тогтмол хэвшүүлэн ажиллаж байна.

Цар тахлын үед Урлаг соёлын тоглолт арга хэмжээ эхэлсэнтэй холбогдуулан **“Их танхим”-ыг ашиглуулах түрээсийн гэрээнд “Хариуцлагын гэрээ”-ээр хүлээсэн “Нийгмийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр УОК-оос гаргасан журам, ажлын байранд тавигдаж халдвар хамгаалалтын дэглэмийг сахиулах, үйл ажиллагааг хэвийн явуулах” нэмэлт өөрчлөлт оруулан хэрэгжүүлж, нийслэл, хөдөө орон нутгийн байгууллагуудаас ирүүлсэн санал, хүсэлт, уран бүтээлчид, урлагийн байгууллага, иргэдийн тоглолт, арга хэмжээний захиалгыг урьдчилан авч, сар бүр зохион байгуулах ажлын график гарган ажиллаж, давхардсан тоогоор нийт **95** удаагийн тоглолт, хурал, лекцийн арга хэмжээнд **106,300 гаруй** хүнд үйлчилсэн байна. Тухайлбал:**

- Ардын дуучин Д.Бурмаагийн “Уянгалаг” бие даасан уран бүтээлийн тоглолт,
- Хязгааргүй дуулал ТББ-аас зохион байгуулсан “Дахин давтагдашгүй” яруу найргийн үдэш арга хэмжээ,
- Монголын АА нийгэмлэгээс зохион байгуулсан “Шинэ алхам бүлэг 20 жилийн ой”-н хурал,
- ХХЕГ-ын Дэд хурандаа С.Алтансэлэмийн “Халдашгүй Эх Орон” уран бүтээлийн тайлан тоглолт,
- Дуучин Дашренчин овогтой Бат-Ундрахын уран бүтээлийн тайлан тоглолт,

- Монголын Тариаланчдын Үндэсний Холбооноос зохион байгуулсан “Газар тариалан - Хамтын Шийдэл” сэдэвт бүх гишүүдийн V чуулган,
- Монгол Улсын Филармониос зохион байгуулсан Морин Хуурын Чуулгын “Best of Playing Love” тоглолт,
- Дуучин Баянмөнхийн “Төр Үр Хоёр Минь Мөнх Оршиг” уран бүтээлийн тоглолт
- Монголын Үндэсний Спортын Хороо” ТББ зохион явуулсан “Монгол магнай” урлагийн тоглолт
- Үндэсний Спортын Анхдугаар Их Чуулганаар хэлэлцүүлэх “Монголын Үндэсний Морин Уралдаан”-ны өнөөгийн байдал, тулгамдсан асуудал, шийдэл сэдэвт нээлттэй хэлэлцүүлэг,
- НЗДТГазар, Хууль Зүй, Дотоод Хэргийн Яам, Германы хамтын ажиллагааны нийгэмлэгээс зохион байгуулсан “Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийн танилцуулах хэлэлцүүлэг,
- Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газраас жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг “Их Хотын Бүсгүйчүүд-2022” хүндэтгэлийн арга хэмжээ,
- “Ганган хөвсгөр” продакшн, “Мэлмий” энтертайнмент”-аас зохион байгуулсан “Plus Size-2022” fashion show арга хэмжээ,
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдаж буй “Нийгмийн Хөгжилд Эрчүүдийн Оролцоо, Манлайлал” үндэсний чуулганы төлөөлөгчдөд зориулсан хүндэтгэлийн тоглолт,
- Казак үндэстний хаврын баяр болох “Наурызын баяр”-т зориулсан “Домборын Эгшиг” хүндэтгэлийн тоглолт,
- Хууль Зүй, Дотоод Хэргийн Яамнаас зохион байгуулсан “Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийн танилцуулах хэлэлцүүлэг,
- Универсал ложистикс Монголиа ХХК-ний “Супервайзоруудын сургалт” өдөрлөг арга хэмжээ,
- “Монголын шагайн харвааны холбоо” ТББ- с зохион байгуулсан “Үндэсний өв соёл-Шагайн харваа” урлагийн тоглолтын арга хэмжээ,
- Нийслэлийн Засаг Даргын санаачлагаар зохион байгуулсан “Циркчдийн зөвөлгөөн” хурлын арга хэмжээ,
- Нийслэлийн Засаг Даргын ивээл дор зохион байгуулсан “Сэтгүүлчдийн чуулган”-ы арга хэмжээ,
- “Монгол-Оросын хамтарсан III сургуулийн “Хонхны баяр”-ын арга хэмжээ,
- Этүгэн их сургуулийн төгсөлтийн баярын арга хэмжээ,
- Потанхау сургуулийн “Урлагийн их наадам-ын арга хэмжээ,
- Монголын балетын үндэсний сургууль ТББ, Монголын Балетын Хөгжил Сангаас зохион байгуулсан “Монголын балетын үндэсний сургуулийн Хаврын Баяр” тайлан тоглолт,
- МУСТА А.Лхамхандын "Уянга төгөлдөр" тайлан тоглолт,
- МЗЭ-ийн гишүүн яруу найрагч, ая зохиогч, МУСТА Анхбаяр “Хайрын орчлон” уран бүтээлийн тайлан тоглолт
- Завхан аймгийн Алдархаан сум 100 жилийг угтсан хандивын тоглолт,
- Монгени сангаас зохион байгуулсан “Монгени сургуулийн ойн баяр”-ын тоглолт,
- Голомт банкнаас ажилчиддаа зориулж зохион байгуулсан Монгол Улсын Морин Хуурын Чуулгын “Best of Playing Love” тоглолт,
- Глобаль удирдагч сангаас зохион байгуулсан “Глобаль удирдагч сургуулийн төгсөлтийн баяр”-ын арга хэмжээ,

- Сүхбаатар дүүргийн нийгмийн хөгжлийн хэлтсээс зохион байгуулсан “Замын хөдөлгөөний цагаан толгой” хурал арга хэмжээ,
  - МУАЖ Дуурийн дуучин Ч.Мөнхшүрийн “Эх үрсийн дуун” уран бүтээлийн тоглолт,
  - Хүүхдийн “Гэгээн театр”-аас зохион байгуулсан “Орчлонгийн хүүхдүүд инээх дуртай” хүүхдийн жүжиг,
  - НГБХЗХГазраас зохион байгуулагдсан Өсвөр үе залуучуудад мэргэжлийн чиг баримжаа олгох “Ирээдүйн эзэд мэргэжил сонголтын аян” арга хэмжээ,
  - Олон улсын Улаанбаатар их сургуулийн “Төгсөлтийн хонхны баяр” арга хэмжээ,
  - Ерөнхий боловсролын 1-р сургуулиас зохион байгуулсан “Урлагийн их наадам”-ын арга хэмжээ,
  - Ховд аймаг Эрдэнэбүрэн сумын 90 жилийн ойд зориулан зохин байгуулсан “Өндөр Алтайн нутаг” тоглолт,
  - Сүхбаатар аймгийн 80 жилийн ойд зориулсан “Талын монгол” хүндэтгэлийн тоглолт”,
  - УИХ-ын гишүүн Б.Саранчимэгийн ажлын албанаас зохион байгуулсан “Хариу нэхдэггүй буянтан” арга хэмжээ,
  - Буриадын Өв Соёлыг Хөгжүүлэх сангаас зохион байгуулсан “Алтаргана 2022” тоглолт,
  - “Орфей театр фильм” ХХК-аас зохион байгуулсан “Гэм Зэм” жүжиг,
  - Дуучин М.Сумьяадоржийн “Соёмбон дор” уран бүтээлийн тоглолт,
  - СЭЗДСургуулийн “Төгсөлтийн хонхны баяр” арга хэмжээ,
  - УИТеатрын “Дэлхийд гайхагдсан Монгол” уран бүтээлийн тоглолт,
  - Монгол Улсын Морин хуурын чуулгын “Монголын сайхан орон” тоглолт,
  - Монгол Улсад орчин цагийн Дотоодын цэрэг үүсэж хөгжсөний 100 жил, Цагдаагийн байгууллага үүсэж хөгжсөний 101 жилийн ойн “Баярын хурал”, Хүндэтгэлийн концерт,
  - Боловсролын ерөнхий газар “Монгол Улсын зөвлөх багш нарын зөвлөгөөн, уулзалт сургалт”-ын нээлт, хаалтын арга хэмжээ
  - Монгол Улсад JCI ТББайгууллага үүсч хөгжсөний 30 жилийн ойд зориулсан Хүндэтгэлийн тоглолт,
  - Ерөнхийлөгчийн тамгын газраас зохион байгуулсан “Эмэгтэй бизнес эрхлэгчдийн зөвлөгөөнд зориулсан үйл ажиллагаа” арга хэмжээ,
  - Таравлин хийдээс зохион байгуулсан “Ном Хурах Өдөр” арга хэмжээ,
  - “Юниверсал ложистикс монголиа” ХХК “Супервайзоруудын сургалт” арга хэмжээ,
  - Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар, Нийслэлийн Ахмадын Хорооноос зохион байгуулсан “Олон улсын ахмадын өдөр 2022” хүндэтгэлийн тоглолт
  - Сүхбаатар дүүргийн МАН-ын хорооны ахмадуудад зориулсан Улаанбаатар театрын “Colors of Mongolia-2022” хүндэтгэлийн тоглолт;
  - Улсын Филармони Монгол Улсын Морин Хуурын Чуулгын “30 жилийн ойн” хүндэтгэлийн тоглолт;
- Засгийн Газрын Хэрэгжүүлэгч Агентлаг Гэр Бүл Хүүхэд Залуучуудын Хөгжлийн газраас зохион байгуулсан Асрамж Халамжийн төвийн өсвөр үе залуучуудын хооронд явагддаг “Azuka Fashion” хоёрдугаар наадам,
- Дуучин М.Золжаргалын “Сэтгэлд үлдэнэ” уран бүтээлийн тоглолт,
  - БЦДБЭЧ-ын гоцлол дуучин МУСТА Н.Батсайханы “Монголын дуу” уран бүтээлийн тоглолт;
  - ОХУ-ын Улан Үдэ хотын Хоца Намсрайевын нэрэмжит Буряад улсын драмын эрдмийн театрын уран бүтээлчдийн аялан тоглолт. "Улей нутгийн охид", "Үхэж ядсан хаан", "Солонгост өнгөрүүлсэн хар өдрүүд", "Шилдэг жүжгүүдийн түүвэр"
  - Нийслэлийн Засаг даргын ивээл дор Нийслэлийн Соёл урлагийн газраас жил бүр уламжлал болгон Нийслэлийн Боловсролын газар, Монголын найрал дууны уран бүтээлчидтэй хамтран зохион байгуулдаг Монгол Улсын Хөдөлмөрийн Баатар,

- Төрийн Шагналт, Ардын жүжигчин Д.Лувсаншаравын нэрэмжит ХХYIII дахь удаагийн “Хүүхдийн найрал дууны наадам”-ын Гала тоглолт;
- Нийслэл Улаанбаатар хот үүсэн байгуулагдсны 383 жилийн ойн хүндэтгэлийн тоглолт
  - Этүгэн Их Сургууль Үүсэн Байгуулагдсаны 20 жилийн ойд зориулсан “Этүгэн Их Сургууль 20” багш оюутнуудын нэгдсэн хүндэтгэлийн тоглолт
  - Монгол-Оросын дипломат харилцаа тогтоосны 101 жилийн ойн хүрээнд Оросын Адыгей Улсын ардын бүжгийн эрдмийн “Нальмэс” чуулга болон Красноярскийн М.Годенкогийн нэрэмжит Сибирийн бүжгийн Улсын эрдмийн чуулгын хамтарсан тоглолт,
  - Монгол Улсын Филармони үүсэн байгуулагдсаны 50 жилийн ойн тоглолт;
  - Монгол Улс, Япон Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ой, Япон Монголын Найрамдал, Соёлын Хамтын Ажиллагааны баярын арга хэмжээнүүдийн хүрээнд зохион байгуулагдсан Японы үндэсний хөгжмийн “KIZUNA” бөмбөрийн хамтлагийн хүндэтгэлийн тоглолт,
  - Чингис хаан одонт, Хөдөлмөрийн баатар, Төрийн Соёрхолт, Урлагийн Гавьяат Зүтгэлтэн, хөгжмийн зохиолч Б.Шаравын 70 насны ойд зориулсан “Баярлалаа” Хүндэтгэлийн тоглолт; (Дууны бүтээл), (Хөгжмийн бүтээл),
  - Хотын стандартын нэгдсэн зөвлөгөөн”-ий хүрээнд зохион байгуулсан “Хотын соёл”, “Иргэдийн ая тухтай орчин” сэдэвт салбар зөвлөгөөн,
  - Монгол Улсын Консерваторийн 85 жилийн ойд зориулсан “Урлагийн эх ундарга” хүндэтгэлийн тоглолт,
  - МУГЖ дуучин Э.Анхбаярын “Монгол ба Сонгодог гранд” уран бүтээлийн тоглолт
  - Монгол Улсын Төрийн хошой шагналт, Ардын жүжигчин, Хөдөлмөрийн баатар Н.Жанцанноровын “Мөнх тэнгэрийн хүчин дор” түүхэн уран сайхны киноны 30 жилийн ойд зориулсан уран бүтээлийн тоглолт,
  - ҮУИТ-ын Дуучин Б.Батцэцэглэнгийн “Ардын дууны концерт”,
  - Их эзэн Чингис хаан мэндэлсний 860 жилийн ой, “Монгол Бахархал”-ын өдөрт зориулсан хүндэтгэлийн тоглолт
  - “Болор Цом-40” яруу найргийн наадам,
  - “Нийгмийн даатгалын байгууллага үүсэж хөгжсөний 80 жил - Хөгжил шинэчлэлийн алсын хараа” зөвлөгөөн, хүндэтгэлийн тоглолт,
  - Дэлхий хамтлагийн шилмэл уран бүтээлүүдээс бүрдсэн албан ёсны анхны “Уухай” тоглолт,
  - "Nomadic" ballet продакшны “Цасангоо ба долоон одой” хүүхдийн балет,
  - Хэнтий аймгийн улсын тэргүүний Баян-Овоо Сум үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойд зориулсан ЗУУНЫ АЯЛГУУ” хүндэтгэлийн тоглолт,
  - МУСТА хийлч Ч.Дэлгэрцэцэгийн DEGI-22” Music visual concert,
  - Төрийн Соёрхолт, МУУГЗ, Харанга хамтлагийн аргил гитарчин, хөгжмийн зохиолч Ц.Чулуунбатын уран бүтээлийн “Хөгжмөөр Хөглөгдсөн 50 жил” хүндэтгэлийн тоглолт,
  - Орхон аймгийн ХЗТеатраас зохион байгуулсан “Асаж буй толгод” хүүхдийн жүжиг,
  - “The English school of mongolia” сургуулийн урлагийн наадам,
  - Монголын Хуульчдын Холбооны үйл ажиллагааны хурал,
  - БЦДБЭЧ-ын түүхт 90 жилийн ойн арга хэмжээ,
  - Глобал Удирдагч Их Сургуулийн 15 жилийн ойн баярын арга хэмжээ,
  - УУХҮЯамны хурал, ойн арга хэмжээ
  - Монгол Улсын филармоний "Snow melody" тоглолт арга хэмжээ, зэрэг хурал, концертуудыг тус тус хамтран зохион байгуулж ажиллалаа.





















### 3.2. Байгууллагын дүрмээр хүлээсэн барилга байгууламж, эд хөрөнгийг аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд зориулалтын дагуу түрээслэх, соёл урлагийн арга хэмжээнд төлбөртэй ашиглуулах” үүргээ хангалттай хэрэгжүүллээ.


#### 3.2.1. Төсвийн орлогын бүрдүүлэлт, төвлөрүүлэлтийн талаар.

Манай байгууллага түрээсийн буюу үзвэр үйлчилгээ, арга хэмжээний орлогоор үйл ажиллагааны санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлж, батлагдсан төсөв, үр дүнгийн гэрээний хүрээнд зардал гарган, төсвийн санхүүжилтийг үр ашигтай зарцуулж, санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэж, хуулийн хугацаанд тайлагнаж ирлээ.

2022 онд иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нийлсэн **51** түрээслэгчтэй түрээсийн гэрээ байгуулан, гэрээний биелэлтийг хангуулж, НИТХ-аас баталсан төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааны зардлаа санхүүжүүлж, төсвийн сахилгыг чанд сахиж ажиллалаа. Нийслэлийн өмчийн байрны түрээс болон тоглолтын орлогоос нийт **1,515,292,825** төгрөгийн орлогыг бүрдүүлэн, байгууллагын үйл ажиллагааны зардлаа **1,160,672,232** төгрөгөөр санхүүжүүлж, батлагдсан төлөвлөгөөний дагуу нийслэлийн төсөвт 2022 онд төвлөрүүлэх ёстой **210,841,581** төгрөг, 2021 оны төвлөрүүлэх орлогын үлдэгдэл **42,390,700** сая төгрөг, нийт **235,000,000** сая төгрөгийг Нийслэлийн Өмчийн харилцааны газарт төвлөрүүллээ.

**Нийслэлийн Соёлын Төв Өргөөний 2000-2022 онд бүрдүүлсэн орлого, төсөвт төвлөрүүлсэн, үйл ажиллагааг санхүүжүүлсэн мөнгөн хөрөнгийн тооцоо**

Д/д	Он	Нийт бүрдүүлсэн орлого /мян.төг/	Зарлага		Захирамжаар /мян.төг/	Төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө /мян.төг/	Хувь
			Зардал санхүүжүүлэх /мян.төг/	Төвлөрүүлсэн орлого /мян.төг/			
1	2000	565,261.6	376666.6	188595		171419.7	110
2	2001	789,100.5	576733	212367.5	10,500.00	176391.7	120.4
3	2002	730,734.7	544884.7	185850	16,950.00	185524.8	105.3
4	2003	704,033.9	496433.9	207600	43,000.00	206400	105.6
5	2004	983,306.7	708514.7	274792	24,050.00	210993.7	135.4
6	2005	1,120,315.8	856616.4	263699.4	87,150.00	263699.4	106.4
7	2006	1,287,005.2	929403.2	357602	98,350.00	345291.8	103.6
8	2007	1,513,564.6	1050507.7	463056.9	6,225.00	375009.6	171.5
9	2008	1,464,915.5	1100407.2	364508.2	50,750.00	364449.2	100
10	2009	1,267,699.4	1017699.4	250000	74,400.00	249340.6	100.3
11	2010	1,388,227.8	1108227.8	280000	88,750.00	280006.2	100
12	2011	1,552,116.9	1239008.6	298428.8	78,575.00	298428.8	100
13	2012	1,694,306.2	1782669.5	450000	44,162.50	304031.9	148
14	2013	1,637,720.6	1372057	380000	147,500.00	377545.2	100.7
15	2014	1,659,664.5	1252664.4	407000	104,500.00	406027.6	100.2
16	2015	1,580,607.1	1157707.1	422900	89,500.00	422000	100.2
17	2016	1,564,740.4	1202740.4	362000	102000	361093.7	100.3
18	2017	1,476,899.4	1109974.5	361247.8	161500	361247.8	100
19	2018	1,396,156.0	1070462.3	325693.7	168500	325193.2	100
20	2019	1,665,383.4	1319455.6	332000	295000	332000	100.2
21	2020	963,758.1	1078049.2	24933.9	49000	0	
22	2021	1,222,439.7	1,113,133.7	109,306.1	112,750.0	151,696.7	72,0
23	2022	1,515,292,8	1,323,227.9	235,000.0	192,000.0	210,841,5	128.0
<b>Дүн</b>		<b>29,786,185.9</b>	<b>23,787,244.8</b>	<b>6,773,581.3</b>	<b>2,045,112.5</b>	<b>6,377,791.6</b>	





### **3.3. Байгууллагын дүрмээр хүлээсэн “Үйлчилгээ явуулах таатай орчин бүрдүүлэх, барилга байгууламж, эд хөрөнгийн ашиглалт, бүрэн бүтэн байдлыг хариуцах” зорилтыг амжилттай хэрэгжүүллээ.**

#### **3.3.1. Үйлчилгээ явуулах таатай орчин бүрдүүлэх, барилга байгууламж, эд хөрөнгийн ашиглалт, өнгө үзэмжийг сайжруулах чиглэлээр дараах ажлуудыг хийлээ. Тухайлбал:**

Өргөөний цогцолборын дулаан, цахилгаан, ус хангамжийн болон хог хаягдал, лифтийн үйлчилгээний аж ахуйн гэрээг байгуулж, найдвартай ажиллагааг хангаж, өвлийн халаалтын дулаан, сантехник, цахилгаан, усан хангамжийн ямар нэгэн доголдол, аваар осолгүй ажиллалаа.

Цахилгаан эрчим хүчний гэрээг 2024 оны 05 дугаар сарын 23-ны өдөр хүртэл 5 жилийн хугацаатай, дулааны эрчим хүчийг худалдах, худалдан авах гэрээг 2028 оны 10 дугаар сарын 01 хүртэл 4 жилийн хугацаатай тус тус сунгалаа.

Түрээслэгч байгууллагуудаас 2022 онд ирсэн санал хүсэлтийг хугацаанд нь барагдуулж, 04 дүгээр сарын 01-нд салхивч, 05 дугаар сарын 01-нд халаалтаа хааж, төлөвлөгөөт засварын ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Өвөлжилтийн бэлтгэлийг хангаж ажиллах үүднээс цонх хаалга дулаалах, гаднаас орох хаалгануудын шатанд зориулалтын халтирхаас сэргийлсэн резин наах, цахилгаан болон дулааны узельд их цэвэрлэгээ хийх, гэрэлтүүлгийг шинэчлэх, ялтсан бойлеруудыг угаах, зэрэг байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан засварын ажлуудыг хийж гүйцэтгэхийн зэрэгцээ түрээслэгч байгууллагуудаас ирсэн дуудлагын дагуу тухай бүрт нь засвар үйлчилгээг чанартай хийж гүйцэтгэж хэвшлээ.

Ээлжийн диспетчерүүд халаалтын улиралд гадна орчны температурын нөхцөлд тааруулан дулаан үед болон амралтын өдрүүдэд градусыг багасгах арга хэмжээ авч ажиллаж байна. Инженер техникийн алба шаардлагатай багаж техник хэрэгсэл, урсгал засварыг батлагдсан төсөвт багтаан хийж гүйцэтгэлээ. Үүнд:


1. А” хэсгийн подвалын складанд халаалтын эргэлтийн шугам цоорч, ус алдсаныг яаралтай арга хэмжээ авч зогсоов. Цоорсон шугамыг таслан авч өгөх хэсгийн 2 стейкийн шугаманд 6 м 20-ийн голчтой PVC хоолойг шинээр холбож халаалтын системийг хэвийн ажиллагаанд нь орууллаа.



2. Уран зургийн галерейн ариун цэврийн өрөөнд хүүхдэд зориулсан угаалтуур шаардлагатай болсон тул төв шугамнаас шинээр холболт татаж угаалтуурыг суурилууллаа. Мөн Улсын Филармоний архивын өрөөнд радиатор шинээр суурилуулж, Хүүхдийн номын ордонд угаалтуур нэмж суулгаж ажиллалаа.




3. Түрээслэгч байгууллагуудын тав тухтай байдлыг хангах зорилгоор өргөөний “Г” хэсгийн 2-р давхрын 100.4 м<sup>2</sup> үргэлжилсэн шалны лак элэгдэж, хуучирч муудсан байсныг шинээр зүлгэж, 3 давхарлаж лакдан, таазыг эмүльсдэж, хуучирсан гэрлийг шинэчилж засварлалаа.



4. ИТА-ны ажиллагсад “Г” корпусын хүйтэн усны шугмыг солих зорилгоор 3 дугаар сарын 13-ны өдөр хүйтэн усыг 09.00-17.00 цаг хүртэл цэвэр усны шугмыг хааж, нээн нийт 14 м шугам сольж ажиллалаа. Мөн Ф-32 мм-ын шугамны изгоныг сольж усны алдагдлаас сэргийлж ажиллалаа.



5. ИТА-ны ажиллагсад “А” хэсгийн 3 ширхэг радиатор цоорч ус алдаж байсныг шинэ радиатор тавьж, завсарлан аюулгүй ажиллагааг ханган ажиллалаа.



6. Дулааны инженер техникч, ИТА-ны ажиллагсад “Г” хэсгийн узельд хуучирч элэгдсэн дулааны төв шугам хагарсан байсныг 12-20 цаг хүртэл төв шугмыг хааж, нээн усны алдагдалгүй болгож засварлалаа.



7. Туушингийн бохирийн шугам бөглөрсөний улмаас дулааны худагруу нэвчин орж байсныг туушингийн засварчидаар бохирийн бөглөөсийг гаргуулж, бохир усыг соруулан цэвэрлэж ажиллалаа



8. Инженер техникийн албаны ажилчид цэвэр усны 74 м шугам хоолойг үе шаттай сольж, усны алдагдал болон аюулгүй байдлаас сэргийлж ажиллалаа.



9. “Фүшили элеватор” ХХК-тай 2022 оны 4-р сарын 01-ний өдрөөс эхлэн хамтран ажиллахаар гэрээ байгуулж, сар бүр хийгддэг лифтний техникийн үйлчилгээний ажил хийгдэж, бүх лифтийг үзлэгт оруулж, лифтний худгийн хогыг цэвэрлэн аюулгүй байдлыг ханган ажиллалаа.



10. Түрээслэгч байгууллагуудын ажиллах тав тухтай орчин нөхцлийг бүрдүүлж, “Г” хэсгийн 2-р давхрын 00-ын өрөөний суултуурыг сольж, шинэчиллээ.



11. ИТА-ны ажиллагсад “Г” хэсгийн 15-р системийн ажиллагаагүй эргэлтийн насосыг шинээр сольж, мөн КЗ буюу урд хэсгийн өрөөнүүдийн эргэлтийн 2 ширхэг насос эвдэрч шатсан байсныг шинээр сольж хэвийн ажиллагаанд оруулж ажиллалаа.



12. ИТА-ны ажиллагсад “А” хэсгийн тайзны хөшиг болон гэрэлтүүлгийн шатыг гагнаж аюулгүй ажиллагааг хангаж ажиллалаа




13. “Г” хэсгийн Кафены гэрэл болон разеткуудыг шинээр сольж, техникийн бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллалаа.



14. Нийслэл дэх Төрийн аудитын газрын 4-р давхарт байрлах өрөөнүүдийн гэрэл болон разеткуудыг шинээр сольж, галын аюул ослоос урьдчилан сэргийлж ажиллалаа.
15. Хүүхдийн төв номын сангийн хуучирч ажиллагаагүй болсон гэрлүүдийг шинээр сольж хэвийн ажиллагаанд орууллаа.
16. ИТА болон СМА-ны ажиллагсад дуудлагын дагуу “Г” хэсгийн 6-р давхрын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл урлагийн газрын өрөөнүүдийн гэрэл болон разетка, унтраалгуудыг шинэчлэн сольж, лифтны холлын хэсгийн шалны элэгдэж хуучирсан лакыг зүлгэж, 3 давхарлан лагдаж засварлан ажиллалаа.




17. “А” хэсгийн коридорын мэдрэгчтэй гэрэлнүүдийг шинээр суурьлуулж, тог цахилгаан болон төсвийг хэмнэж ажиллалаа.



18. Түрээслэгч иргэд болон байгууллагуудын өдөр тутмын үйл ажллагаанд нь байгууллагын зүгээс шаардлагатай тусламж дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах, ажлын уялдаа холбоог сайжруулах үүднээс “Г” байранд Санхүүжилт менежментийн албаны түрээс хариуцсан ажилтан, инженер техникийн албаны дарга нар тогтмол байрлаж, түрээслэгч нарт ойртон ажиллуулахаар “Г” хэсгийн 1-р давхрын мужааны 40 м<sup>2</sup> өрөөг тохижуулж иж бүрэн засвар үйлчилгээ, тохижилт хийж гүйцэтгэлээ. Үүнд: хана, таазны элэгдэж хуучирсан хэсгийг шинээр зүлгэж, кнап болон замаскаа татан, гэрлийн бүрхүүлүүдийг шинээр суурилуулж, хуучирч элэгдсэн модон хаалгыг төмөр хаалгаар шинэчлэн шаланд паркет шахаж, разетки, унтраалгуудыг шинэчилж ажиллалаа.






19. Байгууллагын ажиллагсадын бие бялдар эрүүл мэнд, дархлааг дэмжиж биеийн тамир спортоор чийрэгжүүлж, хөгжүүлэх зорилгоор “А” зоны подвалийн хэсэгт “Фитнессийн өрөө”-г засаж тохижуулахаар засвар үйлчилгээг хийж ажиллаж байна. Төр захиргааны байгууллагууд хэмнэлтийн горимд шилжсэнтэй холбоотойгоор засварын ажлыг 2023 онд хийхээр төлөвлөн ажиллаж байна.



20. “А” хэсгийн ажилчдын хаалганы хоёр талд байрлах шатны хаалтны будаг бороо цасны ус чийгэнд халцран унасныг шавардаж ,замасқдан эмульсээр будаж , мөн эргэн тойрны хаяавч чулуу эмтэрч хагарсныг шинээр чулуу зүсэн тааруулж селиконоор бэхэлж тогтоов.



21. “А” хэсгийн оффисын 313 тоот өрөөний ханын нүхний цоорхой хэсгийг кнапдаж бөглөн дээр нь замаск татаж, таазыг цагаанаар, ханыг цайвар шаргал өнгөөр эмүльсдэж ажиллагсадын ажиллах орчинг сайжруулж ажиллалаа.



22. Маркетинг үйлчилгээний албаны ажиллагсадын байрладаг хувцас солих 2 өрөөг засварлаж, шинээр обой нааж, таазыг эмүльсдэж ажиллагсдын ажиллах орчин нөхцлийг сайжруулж ажиллалаа.



23. Улсын Филармоны нарийн бичгийн өрөөний засварын үеэр шалны доогуур суурилуулсан халаалтын шугамыг өрөмдөж цоолсноос болоод доош ус алдаж, манай хүлээн авалтын өрөөнд их хэмжээний ус хуримтлагдаж хивсэнцэр норж, ханын обойнд мөөгөнцөр үүсч хууларч унасныг обой нааж засвар үйлчилгээ хийж


ажиллалаа. Үүнд: ханын обойг хуулж замаска кнап татаж шинээр обой нааж , цонхны амалгааг эмульсдэж будав. Засварын ажлын дараа өрөөнд цэвэрлэгээ хийлгэлээ.




24. ИТА-ны ажиллагсад 2022 оны 7 дугаар сарын 15-наас 2022 оны 9 дугаар сарын 25-ны өдрийг хүртэлх хугацаанд 3 болон 4 давхруудын хоорондох техникийн давхарт 8 ширхэг бөмбөлгөн 80-ын хаалтыг гагнан тавьж, халаалтын босоо шугамуудын хаалтуудыг (15, 25, 32, 40, 50 хэмжээтэй) 100 гаруйг сольж угсралт хийж ажиллалаа. Нэг хаалт солиход изгон муфтны ком 1 ширхэг тройник, радиатор, хий авагчийн хаалт, үндсэн хаалтуудыг тус тус сольж аюулгүй ажиллагааг ханган ажиллалаа.




25. ИТА нь 6, 12, 1 дүгээр давхруудын 00-ын суултууруудыг сольж, жүжигчдийн болон ажилчдын өрөөний угаалтууруудын бөглөөсийг гаргах, сэлбэх үйлчилгээг цаг тухай бүрт нь хийж гүйцэтгэж ажиллалаа.





26. Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд Нийслэл дэх Төрийн Аудитын газрын захиргаанаас радиатор суулгуулах хүсэлт тавьсаны дагуу 28 радиаторыг сольж тавих үйлчилгээ үзүүлж, аюулгүй ажиллагааг ханган ажиллалаа.



27. ИТА-ны ажиллагсад 6 давхрын ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг Соёл урлагын газарт 7 ширхэг радиатор, МУ-ын Филармонид 4 ширхэг радиатор, Хүүхдийн төв номын санд нэг ширхэг радиатор, Бурхан халдуны тахилгат уулын газарт нэг ширхэг радиатор, диспетчирийн өрөөний 3 ширхэг радиаторуудыг тус тус сольж, түрээслэгч байгууллагуудын тав тух, аюулгүй ажиллагааг ханган ажиллалаа.



28. ИТА-ны ажиллагсад 60-ын оролтон дээр цоорч даралт алдсаныг 11-р сарын 8-ны өдөр "А" зоны дулааныг хааж 2 талд нь шилжүүлэг гагнуулж, PPR шугамаар 15 м орчмыг сольж, засварлан хэвийн ажиллагааг ханган осол аваргүй ажиллалаа.





29. ИТА-ны ажиллагсад цахилгааны чангалгаа үйлчилгээг хэвийн явуулж, үзвэрийн их танхимийн угтах залны гэрэлтүүлгийг шинэчилж эхэллээ.




30. Санхүүжилт менежментийн алба болон Уран бүтээл техникийн албаны ажиллагсад “Г” байрны 1 дүгээр давхрын коридорын хэсгийн хана, таазыг хусаж, замаск болон эмульс татан, ханыг будаж засварласан бөгөөд коридорын хэсгийн босоо шар төмрийн өнгийг сэргээн будаж үйлчлүүлэгч, түрээслэгч байгууллагуудын тав тухтай байдлыг ханган ажиллалаа.





31. Өргөөний бүх ажиллагсад А болон Г байрны подвальд их цэвэрлэгээ хийж, түрээслэгч байгууллагуудын болон өөрийн байрны засвар үйлчилгээ, дулаалгын үед гарсан хур хогийг цэвэрлэж ачууллаа.



32. “Г” байрны үүдний хэсэгт байрлах байгууллагуудын хаягийг авч цэвэрлэн, үүдний ханын хэсгийг бүрэн будаж байгууллагуудын хаягыг тогтоож, Нийслэлийн Өмчийн байрны ашиглалт хамгаалалт, өнгө үзэмжийг сайжруулж ажиллалаа.





33. Г байрны 1 дүгээр давхрын диспетчирийн өрөөний хуучирч эвдэрсэн хаалга болон коридорын подваль руу орох хэсгийг тусгаарлах зорилгоор нийт 2 ширхэг бүргэд хаалга суурилуулж, нийслэлийн өмчийн байрны ашиглалт хамгаалалт, өнгө үзэмжийг сайжруулахад анхаарч ажиллалаа. Мөн “А” байрны оффисын нийт хаягийг шинэчилж ажиллалаа.



### **3.4. Байгууллагын дүрмээр хүлээсэн “Үйл ажиллагаанд шинэ техник технологийг нэвтрүүлэн үр дүнг дээшлүүлэх, менежментийг боловсронгуй болгох” үүргээ хангалттай хэрэгжүүллээ.**

### **3.5. Албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах талаар дараах ажлуудыг хийлээ.**

**Байгууллагын хүний нөөцийг хөгжүүлэх,** сургалтад хамруулах, ажиллах нөхцлийг сайжруулах, нийгмийн баталгааг хангахад Засгийн газрын 2017 оны 243 дугаар тогтоол, Засгийн газраас 2018 онд баталсан “Төрийн албаны сахилга, хариуцлага, дэг журмыг чангатгах” 258 тогтоол, Нийслэлээс 2022 оныг “Хотын иргэний жил” болгож, 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”, “Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасны хугацааны нэмэгдэл олгох журам”, “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэсэгдэл хөлс олгох журам”, “Төрийн үйлчилгээний албан хаагчид мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох нийтлэг журам”, Төрийн албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”, Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-уудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байна.

Мөн албан хаагчдын эрүүл мэнд, ажлын байрны нөхцөл сайжруулах, сургах, мэргэшүүлэх, үйлчилгээ, харилцааны соёл эзэмшүүлэх, хүний нөөцийн судалгаа, албан хаагчдын хувийг хэргийг жил бүр шинэчлэн өөрчлөх, бүрдүүлэх, мэдээллийн ил тод байдлыг хангах, зэрэг олон ажлыг үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусгаж, хэрэгжүүлж хэвшлээ. Тухайлбал:

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 04 дүгээр хавсралтын дагуу албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах талаар жилийн ажлын төлөвлөгөөнд тусгасан зорилтын биелэлтийг дараах чиглэлээр тооцон гаргалаа. (Хавсралт хүснэгтээс үзнэ үү)

#### **3.5.1. Хүний нөөцийг хөгжүүлэх идэвхжүүлэх чиглэлээр:**

**3.5.1.1. Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэхээр** зохион байгуулсан сургалтад нийт 29 сургалт, зөвлөгөөнд 259 албан хаагч (давхардсан тоогоор) хамрагдлаа. Үүнээс туршлага солилцох зөвлөгөөнд 8 албан хаагч оролцож, бусад сургалтад 251 албан хаагч оролцсоны 149 нь эмэгтэй, 102 нь эрэгтэй, 8 удирдах ажилтан, 243 нь гүйцэтгэх, туслах ажилтан байна.

Сургалт, семинар, зөвлөгөөнд хамрагдагсдын тоо нийт албан хаагчдын 86.2 %-ийг эзэлж байна.

**Мэргэшэх чиглэлээр** Бичиг хэрэг, архив хариуцсан захирлын туслах Я.Оролжидсүрэн Монголын хүний нөөцийн удирдлагын академид Нарийн бичиг, архивын мэргэшүүлсэн 45 хоногийн сургалтад 2022 оны 03 дугаар сарын 20-ны өдрөөс 05 дугаар сарын 08-ны өдөр хүртэлх хугацаанд хувийн зардлаар суралцаж амжилттай төгслөө. Мөн тооцооны нягтлан бодогч Д.Гэрэлтуяа Монголын Мэргэшсэн нягтлан бодогчдын институтаас зохион байгуулдаг “Санхүүгийн тайлагнал” хичээлийн сургалтад 2022 оны 10-р сарын 01-ний өдрөөс 11-р сарын 01-ний өдрийг дуустал 1 сарын хугацаанд хувийн зардлаар амжилттай суралцлаа.

(Сургалтад хамрагдсан дэлгэрэнгүй тайланг хавсралтаар үзүүлэв)

### **3.5.1.2. Албан хаагчдыг байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр гадаад сургалтад хамруулаагүй.**

Дэлхийн улс орнуудад тархаад байгаа “Коронавирус /COVID-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх, иргэдийн эрүүл мэндийг халдварт өвчнөөс хамгаалах зорилгоор Улсын хэмжээнд Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжиж, улмаар соёл урлагийн байгууллагын үйл ажиллагааг I улиралд хязгаарласан, мөн “Төрийн хэмнэлтийн тухай” хуулийн хэрэгжилтийн хүрээнд (15.2.3.сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилот болон холбогдох бусад зардлыг хэмнэх;) зарим зардлыг хэмнэж, мэргэшүүлэх сургалтад хамрагдах албан хаагчдыг хувийн зардлаар нь сургаж ажиллалаа.

### **3.5.1.3. Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт, хөдөлгөөнийг авч үзэхэд**

Өөрсдийн зардлаар Бичиг хэрэг, архив хариуцсан захирлын туслах Я.Оролжидсүрэн Монголын хүний нөөцийн удирдлагын академид Нарийн бичиг, архивын мэргэшүүлсэн 45 хоногийн сургалтад 550,000 төгрөгөөр, тооцооны нягтлан бодогч Д.Гэрэлтуяа Монголын Мэргэшсэн нягтлан бодогчдын институтаас зохион байгуулдаг “Санхүүгийн тайлагнал” хичээлийн сургалтад 275,000 төгрөгөөр тус тус хамрагдан шалгалтад амжилттай тэнцэж, сертификатаа гардан авсан байна.

- Албан хаагчдыг томилсон, чөлөөлсөн хөдөлгөөний тайлангаар 2022 онын 01 дүгээр сарын 01-ний байдлаар нийт 46 албан хаагч ажиллаж байсан бол 2022 оны 12 дугаар сарын 10-ны байдлаар 55 албан хаагч ажиллаж байна. Энэ хугацаанд 2022 оны Монгол Улсын Засгийн “Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 203 дугаар тогтоол, 2022 оны Нийслэлийн Засаг даргын А/657 дугаар захирамжийн дагуу Ерөнхий инженер буюу Дэд захирал Н.Энхбат ажлаас чөлөөлөгдсөн.

- Албан тушаалын тодорхойлолтын шаардлагыг хангасан архив, бичиг хэргийн ажилтан, маркетингийн ажилтан, хүний нөөцийн ажилтан, дууны инженер, тайзны машинист, уран сайхны удирдагч, дуучин, жолооч, сантехникийн ээлжийн диспетчер, үйлчлэгч, ээлжийн жижүүр нарын 25 иргэнийг ажилд томилж, 1 ажилтан орон тооны цомхотголоор, 4 ажилтан тэтгэвэр тогтоолгохоор, 12 албан хаагч өөрийн хүсэлтээр ажлаас тус тус чөлөөлөгдсөн байна.

### 3.5.2 Албан хаагчдын шагнал, нийгмийн баталгааг хангах чиглэлээр:

**3.5.2.1. Албан хаагчдын цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэхэд** цалинд **383,477.1** мянган төгрөгийг, төрийн алба хаасны нэмэгдэлд **25,931.5** мянган төгрөгийг, ур чадварын нэмэгдэлд **30,491.2** мянган төгрөгийг, хоол унаанд **64,711.0** мянган төгрөгийг, хавсран ажилласны хөлсөнд **43,876.2** мянган төгрөгийг, үр дүнгийн урамшуулалд **43,871.8** мянган төгрөгийг, шөнийн нэмэгдэлд **3,265.6** мянган төгрөгийг, илүү цагт **11,967.7** мянган төгрөгийг тус тус олгож, нийт **607,592.1** мянган төгрөгийг зарцуулсан байна.

Тэмдэглэлт баяр ёслолоор ажил хөдөлмөрөөрөө бусдыгаа манлайлж ажилласан албан хаагчдыг захиргааны зөвлөлөөр шагналд тодорхойлж, “Соёлын тэргүүний ажилтан” цол тэмдэгээр Уран бүтээл техникийн албаны дарга Ч.Батчулуун, Нийслэлийн Засаг даргын жуух бичгээр Д.Энхтүвшин, Уламсүрэн, Нийслэлийн хүндэт тэмдэгээр Л.Мандах, Нийслэлийн тэргүүний ажилтнаар ахлах няглан бодогч Ө.Цолмон, Монгол Улсын Сангийн яамны сайдын тушаалаар Санхүү банкны тэргүүний ажилтнаар нягтлан бодогч Д.Гэрэлтуяа, Ц.Пүрэвсүрэн нар тус тус шагнагдсан амжилттай ажиллалаа.

**3.5.2.2. Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцлийг бүрдүүлэх чиглэлээр хамт олноос санал авч, дараах ажлуудыг хийлээ.**

- Албан хаагчдыг тав тухтай орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлж, түрээслэгч байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах үүднээс “Г” байранд Санхүүжилт менежментийн албаны түрээс хариуцсан ажилтан, Инженер техникийн албаны дарга нар тогтмол байрлаж, түрээслэгч нарт ойртон ажиллуулахаар “Г” хэсгийн 1-р давхрын мужааны 40 м<sup>2</sup> өрөөг тохижуулж иж бүрэн засвар үйлчилгээ хийж гүйцэтгэлээ. Үүнд: хана, таазны элэгдэж хуучирсан хэсгийг шинээр зүлгэж, кнап болон замаскаа татан, гэрлийн бүрхүүлүүдийг шинээр суурилуулж, хуучирч элэгдсэн модон хаалгыг төмөр хаалгаар шинэчлэн шаланд паркет шахаж, разетки, унтраалгуудыг шинэчилж ажиллалаа.
- Маркетинг үйлчилгээний албаны ажиллагсадын байрладаг 2 өрөөний хуучирч урагдсан обойг хуулж шинээр нааж, таазыг эмүльсдэж ажиллагсдын ажиллах орчин нөхцлийг сайжруулж ажиллалаа.
- Маркетингийн ажилтны байрладаг “А” хэсгийн оффисын 313 тоот өрөөний ханын нүхний цоорхой хэсгийг кнапдаж бөглөн дээр нь замаск татаж, таазыг цагаанаар,

ханыг цайвар шаргал өнгөөр эмүльсдэж, ажиллах орчинг сайжруулахад анхаарч ажиллалаа.

- Санхүүжилт менежментийн алба болон Уран бүтээл техникийн албаны ажиллагсад “Г” байрны 1 дүгээр давхрын коридорын хэсгийн хана, таазыг хусаж, замаск болон эмүльс татан, ханыг будаж засварласан бөгөөд коридорын хэсгийн босоо шар төмрийн өнгийг сэргээн будаж үйлчлүүлэгч, түрээслэгч байгууллагуудын тав тухтай байдлыг ханган ажиллалаа.

### 3.5.2.3. Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх чиглэлээр

- 2022 жилийн эцсийн байдлаар байгууллагын нийт ажилтан албан хаагчид урьдчилан сэргийлэх вакцины I, II тунд бүрэн хамрагдсан бөгөөд вакцины III тунд 38 ажилтан хамрагдаж, вакцины III тунгийн хамрагдалт 84,4%-тай байна.
- Байгууллагын ажилтан албан хаагчдад эрүүл зөв хооллолтыг сурталчлах, эрүүл мэндийн боловсрол олгох зорилгоор УБ театрын дотоод ажил хариуцсан мэргэжилтэн Б.Өнөрцэцэгийг урьж, “Эрүүл зөв хооллолт” богино хугацааны сургалтыг 2022 оны 06 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулж ажиллалаа.




- Биеийн тамин спортын идэвхитэй хөдөлгөөнийг энгийн дасгал болох алхалт гүйлтээр хичээллэхэд уриалах, бие бялдрыг чийрэгжүүлэх, эрүүл зөв амьдралын дадал хэвшилд сургах зорилгоор 2022 оны 03 дугаар сарын 28-ны өдөр Богдхан уулын бэлээс “Дугуй цагаан” руу явган аялал, алхалтыг зохион байгуулж, ажилчдын дунд мэдлэг оюун шалгах АХА тэмцээн, биеийн тамирын дасгал хөдөлгөөн хийж, хурд хүч авхаалж самбааг шаардах гүйлтийн багийн тэмцээн уралдааныг амжилттай зохион байгуулж, нэг өдрийг хөгжөөнтэй, зугаатай өнгөрөөж ажиллалаа.



- Нийслэлийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийг Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Иргэдийг биеийн тамир, спортын үйл ажиллагаанд татан оролцуулах, хөдөлгөөний хомсдлоос урьдчилан сэргийлэх, эрүүл зөв амьдралын хэв маягийг хэвшүүлж дадал болгох зорилгоор улс орон даяар хэрэгжүүлж буй Монгол Улсын Ерөнхий Сайдын санаачилсан “Илүүдэл жингүй-Эртэч Монгол” аянд нэгдэж, 2022 оны 03-р сарын 10-ны өдрөөс 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд Захиргааны зөвлөлийн гишүүд идэвхитэйгээр байгууллага хамт олноо уриалж оролцлоо. Аяны хүрээнд Пүрэв гариг бүрт 06:30-07:30 цагийн хооронд нийт 11 удаа Спортын төв ордонд, Үндэсний цэцэрлэгт хүрээлэн, Сүхбаатарын талбайд захирал Д.Ариунбаатар болон албадын дарга нар албан хаагчдын хамт дасгал хөдөлгөөнийг тогтмол хийж хэвшин эрүүл зөв амьдралын хэв маягт шилжиж, илүүдэл жингээ хасаж, Саруул багшийн заасан нурууны дасгалыг ажлын байран дээр хийж хэвшүүлэхийн зэрэгцээ хөдөлгөөний хомсдлоос урьдчилан сэргийлж дугуй унах, заал авч тоглох, байгууллага хамт олноороо Богд ууланд явган аялал хийх зэрэг ажлуудыг зохион байгуулж, давхардсан тоогоор 270 албан хаагчдыг хамруулж ажилласан. Мөн байгууллагын Төв Өргөө Төв Өргөө цахим хуудсаар олон нийтийг уриалж сурталчилж ажиллалаа







- Байгууллагын ажиллагсадын эрүүл мэндийг хамгаалахад анхаарч Сүхбаатар дүүргийн эрүүл мэндийн нэгдсэн эмнэлэгт 2022 оны 12 дугаар сарын 06,07-ны өдрүүдэд “Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг”-т байгууллагын 55 ажилтан албан хаагчдыг амжилттай хамруулж ажиллалаа.

#### 3.5.2.4. Албан хаагчдыг нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал.

Төрийн албаны тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-ын хэрэгжилтийг хангаж, 2022 онд өндөр насны тэтгэвэр тогтоолгосон 2 албан хаагчид IV улиралд **25,511,200** төгрөгийг, гачигдлын улмаас 4 албан хаагчдын ар гэрт нь **2,000,000** төгрөг, буцалтгүй тусламжид **4,857,814**, Эх үрсийн баярын өдөр нийт ажилтнуудын хүүхдүүдэд **1,429,000** төгрөгийг бэлгэнд зарцуулж нийт **35,511,200** төгрөгийг жилд олгохоор төлөвлөснөөс **33,798,014** төгрөгийг 2022 онд олгосон байна.



#### 3.5.3. Албан хаагчдын ажлын сахилга, хариуцлагыг сайжруулах, ил тод байдлыг хангах чиглэлээр.

- Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн хэрэгжилтийг ханган ажиллах, холбогдох заалтыг байгууллагын дотоод журамд тусгаж хэрэгжүүлж байна. Мөн Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн 1.2 дах заалтыг үндэслэн байгууллагын чиг үүрэг, үйлчилгээний онцлогийг харгалзан албан хаагчдын ёс зүйн дүрмийг боловсруулан гаргаж, мөрдөж ажиллаж байна. 2022 оны албан хаагчдаас ёс зүйн зөрчил гаргаагүй болно.
- Ажлын байрны сул орон тооны зар, хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр, албан хаагчдын ёс зүйн дүрэм, “Албан хаагчдын дагаж мөрдөх хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм”, албаны “Албан хаагчдын дагаж мөрдөх хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны журам”-ыг цахим хуудас, мэдээллийн самбарт байрлуулсан байдаг.
- Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг албадын үйл ажиллагааны онцлогийг харгалзан, албадын ажлын тайланг алба, нэгж бүрээр захирлын зөвлөлийн хурлаар оруулан хэлэлцүүлж, ажлын гүйцэтгэлийг нь дүгнэж, хэвшсэн. Улмаар албадын үйл

ажиллагааны чиглэлээр нийт ажилчдын саналыг сонсож, ирэх жилд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд тусган ажиллаж байна.

### **3.6 Архив, албан хэрэг хөтлөлт, хариутай албан бичгийн шийдвэрлэлтийн талаар дараах ажлуудыг хийлээ. Үүнд:**

#### **www.edoc.ulaanbaatar.mn-ийг ашиглан:**

Нийслэлийн байгууллагуудад иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн албан бичиг шийдвэрлэхэд ашиглагдаж буй [www.edoc.ub.gov.mn](http://www.edoc.ub.gov.mn) цахим программаар:

**Ирсэн албан бичиг:** Тайлант хугацаанд нийт 301 албан бичиг ирсэнээс 102 хариутай бичгийг хүлээн авч тухай бүрд нь холбогдох албан тушаалтанд танилцуулж хугацаатай албан бичгийн хариуг хугацаанд нь явуулсан.

**Явуулсан албан бичиг:** Тайлант хугацаанд нийт 207 албан бичиг явуулсан. Үүнээс 77 хариутай бичиг, 130 хариугүй албан бичгийг тус тус явуулсан.

#### **www.erp.ulaanbaatar.mn-ийг ашиглан:**

**Өргөдөл гомдол:** Ажилтнуудаас хандсан өргөдөл гомдол нийт 63-г хүлээн авснаас ажилд орох хүсэлт 27, ажлаас чөлөөлөгдөх хүсэлт 15, тэтгэмж, нэмэгдэл хөлс хүссэн 3, ажлын чөлөө хүссэн 18 өргөдлийг тус тус хүлээн авсан.

**Тушаал:** “Б” тушаал 97 гарснаас үүнээс ажлаас чөлөөлөх 19, ажилд авах 37, нэмэгдэл цалин олгох тухай 31, буцалтгүй тусламж олгох 8, ээлжийн амралт эдлүүлэх тухай 2 тушаал гарсан байна. Үндсэн үйл ажиллагаатай холбоотой “А” тушаал 51 гаргаж, хэрэгжүүлсэн байна.

### **Дөрөв. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал.**

**4.1. Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангаж,** төсвийн хөрөнгийн батлагдсан төлөвлөгөө, зарцуулалтын сар улирлын мэдээ, тайлан балансыг цахимаар Нийслэлийн төрийн санд өгч, шилэн дансанд тухай бүр байршуулж, байгууллагын сайтад тавьж нийтэд толилуулж ирлээ.

Мөн түрээсийн буюу үзвэр үйлчилгээ, арга хэмжээний орлогоор үйл ажиллагааны санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлж, батлагдсан төсөв, үр дүнгийн гэрээний хүрээнд зардал гарган, төсвийн санхүүжилтийг үр ашигтай зарцуулж, санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэж, хуулийн хугацаанд тайлагнаж хэвшлээ.

**4.2. Үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, дараах ажлуудыг хийж, хэвшүүллээ.**

4.2.1. Нийслэлийн Засаг даргын “Мэдээллийн ил тод байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” 2012 оны А/606 дугаар захирамжийн дагуу байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийг цаг тухайд нь цахим сайтад байршуулан, ил тод байдлыг хангаж ажиллаж ирлээ. 2021 оны аудитын үнэлгээ, захирлын А тушаал, ирсэн бичгийн шийдвэрлэлтийн мэдээ, хөрөнгө худалдаж авсан мэдээлэл,

2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, 2022 оны үйл ажиллагааны тайлан, ажлын байрны зар, шинээр ажилд орсон болон гарсан албан хаагчдын хөдөлгөөний мэдээ зэргийг байршуулж ажиллалаа.

Мөн цаг үеийн мэдээллийн самбарыг ажилд оруулж өдөр тутмын ажил, тоглолтын график, ажлын дуудлага байрлуулж өдөр, тутмын шинэ мэдээ мэдээллээр хангаж, байгууллагын сайтыг тогтмол ажиллуулж хэвшүүлээ.

- 4.2.2. Үйлчилгээний ажлын ил тод байдлыг хангах зорилгоор санал, хүсэлт, сэтгэгдлийг нийтийн ариун цэвэр, угтах үйлчилгээ, үйлчилгээний ажилтны харилцааны соёлын чиглэлээр сэтгэл ханамжийн асуулгыг түрээслэгч байгууллагуудаас 6 чиглэлийн асуулга хуудсаар авч хэвшүүлээ.
- 4.2.3. Албан хаагчдын сахилга, үйл ажиллагааны аюулгүй байдлыг 40 камераар байнга хянаж, Ковид-19 цар тахлын үед албан хаагчдын ажилд ирсэн, явсан цагийг ERP цахим системээр бүртгэлжүүлж, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхлэхтэй холбогдуулан цаг бүртгэлийн төхөөрөмжид хадгалагдаж байсан 79 албан хаагчдын биеийн давхцахгүй өгөгдөл (гарын хурууны хээ)-ийг устган, серверийг форматлаж хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллалаа.
- 4.2.4. Нийслэлийн ЗДТГ-аас ирүүлсэн Ажлын цагийн бүртгэлийг сайжруулах тухай 2022 оны 03/5913 албан бичгийн хэрэгжилтийг хангаж, Нийслэлийн Соёлын Төв Өргөөний цаг бүртгэлийн төхөөрөмжийг 2022 оны 11 сарын 23-ны өдрөөс эхлэн [erp.ulaanbaatar.mn](http://erp.ulaanbaatar.mn) системийн “Цаг бүртгэлийн дэд систем”-д холбуулж ажиллалаа.

### **4.3 Хүний нөөцийн бодлогын ил тод байдлыг хангаж дараах ажлуудыг хийлээ.**

- 4.3.1. Албан хаагчдын ёс зүйн дүрмийг болон ажлын байрны сул орон тооны зарыг цахим хуудас, мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулж, тухай бүрт нь шинэчилж байна.
- 4.3.2. Хөдөлмөрийн тухай хуулийн өөрчлөлттэй холбогдуулан 2022-2026 оны Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг дахин боловсруулж ажиллалаа.
- 4.3.3. Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг албадын үйл ажиллагааны онцлогийг харгалзан, албадын ажлын тайланг алба, нэгж бүрээр захирлын зөвлөлийн хурлаар оруулан хэлэлцүүлж, ажлын гүйцэтгэлийг нь дүгнэж ажиллалаа.

### **4.4 Байгууллагын гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилтын хүрээнд дараах ажлуудыг хийлээ.**

- 4.4.1. Соёл Эрдэнэ хамтлагийн Уран сайхны удирдагч, дуучин Б.Хонгор Франц улсад зохиогдсон “Каннын 75 дахь удаагийн олон улсын кино наадам”-д эх орноо төлөөлж амжилттай оролцож, Каннын театрын гэрэл, дуу, шумны техник тоног төхөөрөмжтэй танилцаж, ажлын туршлага солилцож ажиллалаа.



4.4.2. Бүгд найрамдах Киргиз улс, Монгол улсын хооронд дипломат харилцаа үүсэж хөгжсөний 30 жилийн ойн арга хэмжээнд өргөөний маркетинг, гадаад харилцаа хариуцсан ажилтан М.Амарсанаа урилгаар оролцож, тухайн орны урлаг соёлын салбарын байгууллагуудаар зочлон уулзалт хийж, ажлын туршлага солилцлоо.




4.4.4 Орос, Монголын найрамдлын сарын хүрээнд Монгол Улсын гадаад ертөнц дэх Соёлын бүрэн Эрхэт Элч, МУСГЗ Х. Дамдинсүрэнтэй хамтран 2022 оны 11 сарын 3,4-ны өдрүүдэд хамтын ажиллагааны М.С.Годенкогийн нэрэмжит Красноярск хотын улсын СИБИРЬ бүжгийн эрдмийн чуулга, Улсын АДЫГЕЙН ардын бүжгийн эрдмийн “Нарьмэж” чуулга хүрэлцэн ирж уран бүтээлийн тоглолтоо өргөөнд амжилттай зохион байгууллаа. Мөн тус үйл ажиллагааны үед “Нарьмэж” чуулга, СИБИРЬ

бүжгийн эрдмийн чуулгын балетмestr багш нараар Монголын СУИС, МУ-ын консерваторын бүжиг ангийн оюутан залуучуудад мастер класс сургалтыг бидэнтэй хамтран зохион байгуулж үр дүнтэй ажиллалаа.



4.4.3. ОХУ-ын Буряадын Хоца Намсрайевын нэрэмжит Буряад улсын драмын эрдмийн театрын уран бүтээлчдийн аялан тоглолт 2022 оны 10 дугаар сарын 17, 18, 19, 20-ны өдрүүдэд 2022.10.17-ны өдөр "УЛЕЙ НУТГИЙН ОХИД" 2022.10.18-ний өдөр "ҮХЭЖ ЯДСАН ХААН" 2022.10.19-ны өдөр СОЛОНГОСТ ӨНГӨРҮҮЛСЭН ХАР ӨДРҮҮД" 2022.10.20-ны өдөр "ШИЛДЭГ ЖҮЖГҮҮДИЙН ТҮҮВЭР" жүжгүүдийг Нийслэлийн Соёлын төв өргөөний тайзнаа 4 өдрийн турш амжилттай зохион байгуулж, аялан тоглолтыг дэмжин ажиллалаа.





Төрийн шагналт, МУАЖ Ц.Намсрайжавын нэрэмжит Монгол Улсын Филармони үүсэн байгуулагдсаны 50 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулах ажлын хүрээнд Өргөөнөөс Япон Улсын засгийн газрын “Өвсний Үндэс” буцалтгүй тусламжийн төсөлд хамрагдах, хамтран ажиллах тухай дэмжлэг үзүүлэхийг хүсч хамтран ажиллалаа. Тус буцалтгүй тусламжаар Монгол Улсын Филармоны концертийн танхимыг иж бүрэн засварласан бөгөөд гүйцэтгэгч Сеттимо ХХК **233.2 сая төгрөгөөр** засвар үйлчилгээг чанартай хийж гүйцэтгэсэн байна.. Үүнд:

- ✓ Үзэгчдийн танхимын хуучин сандлуудыг буулгаж, 260 ширхэг сандлыг бүрэн шинэчлэн суурилууллаа.
- ✓ Бага танхимын хана, тайзны нүүрэн тал болон зрителын орох гарах хаалгыг акустик хавтангаар сольсон.
- ✓ Заалны хуучин зүймэл царсан шалыг хуулж, дахин шахаж зүлгэж лагдсан.
- ✓ Дуу техникийн өрөөний таазыг дүүжин тааз болгон эмульсдэж, дотор ханыг ОСП хавтангаар бүрж, орж гарах шат, хаалгануудыг шинээр хийсэн.
- ✓ Ашиглалтын хугацаа нь дууссан радиатор паарнуудыг сольж, хуучин дулааны шугам хоолойг буулган шинэчлэн угсарлаа.
- ✓ Цохны хаалтыг акустик хавтангаар сольсон.
- ✓ Дотор ханыг бүхэлд нь акустик хавтан, гоёлын ханаар доторлолоо.
- ✓ Дотор хананд акустик хавтан далбаанд нүдэн гэрэл суурилууллаа.



**Тав. Цаг үеийн шаардлагаар хийсэн ажлын үр дүн.**

**5.1. Улс, Нийслэл, дүүргийн удирдлагаас ирүүлсэн шийдвэрийн хэрэгжилт.**

Дээд газраас ирүүлсэн болон Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Онцгой комисс, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын албан тоот, Улаанбаатар хотын ерөнхий менежерийн албан тоот зэрэг нийт **125** шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажилласан болно.



## 5.2. Нийслэл, дүүргийн удирдлагаас цаг үеийн асуудлаар өгсөн үүрэг даалгаварын хэрэгжилт.

5.2.1 Коронавируст халдвар (Ковид-19)-аас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах чиглэлээр Улсын болон Нийслэлийн Онцгой комиссын даргын тушаалаар батлагдсан түр журам, соёл урлагийн арга хэмжээнд тавигдах тусгай нөхцөл шаардлага, холбогдох үйлчилгээний ерөнхий стандартуудыг хөл хорионы үеэр мөрдөн ажиллалаа. Үүнд:

- Их танхимын үзэгчдийн орох, гарах хэсгийг тусдаа нэг чигийн урсгалтай байхаар зохион байгуулж үзэгч, үйлчлүүлэгчдэд хяналт тавьж ажиллалаа.
- Тоглолт арга хэмжээ зохион байгуулагч иргэн, ААНБ-тай их танхим ашиглуулах гэрээ байгуулахдаа Түргэвчилсэн шинжилгээ авах лабораторийг ажиллуулах, III тунд хамрагдсан иргэдийг иргэний үнэмлэх болон нэмэлт тунд хамрагдсан гэрчилгээгээ цахимаар эсвэл цаасаар үзүүлж нэвтрүүлэх, нэмэлт III тунд хамрагдаагүй иргэдийг шинжилгээнд хамруулах талаар гэрээнд тусгаж, Түргэвчилсэн шинжилгээний төлбөрийг тоглолт арга хэмжээ зохион байгуулагч иргэн, ААНБ бүрэн хариуцан ажиллалаа.
- Их танхимын дүүргэлтийг 50%-иас хэтрүүлэхгүй байхаар буюу 1 суудал алгасуулж 1 хүн суулгахаар зохион байгуулалт хийж, хяналт тавьж ажиллалаа.
- Орох хэсгийн 2 талд хяналтын ажилтныг ажиллуулж, үйлчлүүлэгчдийн дархлаажуулалтад хамрагдсан байдлыг шалган ажиллалаа.
- Ажилчдын болон үйлчлүүлэгчдийн хаалганы орох, гарах хэсэгт гар халдваргүйжүүлэх спиртэн суурьтай уусмал байршуулж хэвшлээ.
- Тасалбарыг цахимаар авах боломжийг бүрдүүлж, Ticket.mn цахим сайтаар тасалбар худалдаалах зөвлөмж өгч ажиллалаа.
- Цар тахлаас урьдчилан сэргийлэх, үзэгчдийн үзвэр үзэх соёлыг дээшлүүлэх зорилгоор “Аудио бичлэг”-ийг хийн хүргэж ажиллалаа. Тус аудио бичлэгийг Соёлын Төв Өргөөгөөр үйлчлүүлсэн иргэдэд арга хэмжээ эхлэхээс өмнө тогтмол явуулж хэвшлээ.
- Их танхим, фоей, хүлээлгийн хэсэгт бөөгнөрөл үүсгэхгүй, үзэгч хоорондын зай барих, тэмдэглэгээг байршуулан мөрдүүлж ажиллалаа.
- Ариутгал халдваргүйжүүлэлтийг тухай бүр мэргэжлийн байгууллагаар хийлгэж хэвшлээ.



**5.2.2.** Монгол улсын Шадар сайдын 2021 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн 142 тоот тушаалаар баталсан удирдамжийн дагуу өгсөн үүрэг даалгавар чиглэлийн хүрээнд Хан-Уул дүүргийн 21 дүгээр хороог хариуцан Мэргэжлийн Хяналтын Ерөнхий газрын ЭАХХХУАБайцаагч Б.Шинэдаваагаар ахлуулан, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын БОХУБайцаагч М.Мөнгөнчимэг, НСТӨ-ний захирал Д.Ариунбаатар, жолооч Ш.Пүрэвдэмбэрэл, 21-р хорооны I болон VII хэсгийн ахлагч О.Буяннэмэх, Д.Мөнхжаргал нарын 6 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг сайжруулсан түлшний хэрэглээ, зарцуулалт, нөөцөд хяналт тавьж ажиллахаар 2022 оны 01 дүгээр сарын 07-09-ний өдрийн 08.00-20.00 цагийн хооронд нийт 37 өрх айлаар орж хяналт тавьж ажиллалаа. Хан-Уул дүүргийн 21 дүгээр хорооны иргэдээс түлшний цэг байдаггүй, түлшний хүрэлцээ муу байгаа талаар болон уутны хэмжээ багассан, түлшний чанар өмнөх жилээс муудсан талаар гомдол санал өгсөн байна.





**5.2.3.** Нийслэлийн Онцгой комиссын даргын 2021 оны 15 дугаар тушаалаар дархлаа сэргээх нэмэлт тунгийн хамрагдалтыг эрчимжүүлэх, зорилгоор Хан-Уул дүүргийн 21-р хороо болон 18-р хороонд дархлаажуулалтын ажлыг эрчимжүүлэх, сайжруулсан түлшний хэрэглээг эрчимжүүлэхэд хяналт тавих зорилгоор 2021 оны 12-р сарын 15-ны өдрөөс 2022 оны 03-р сарын 24-ний өдрийг хүртэлх хугацаанд ажилласан бөгөөд байгууллагын 30 ажилтан албан хаагчдыг хамруулж ажиллалаа.

Манай албан хаагчид 2 хороонд хуваарьлагдаж, хорооны хэсгийн ахлагч нартай давхардсан тоогоор 800 гаруй аж ахуй нэгж байгууллагуудаар явж, вакцинада идэвхитэй хамрагдах талаар уриалж, хорооны өрхийн эмнэлэгт 09.00-20.00 цагийн хооронд харъяа харгалзахгүй хийж байгаа талаар заавар зөвлөмж хүргүүлж ажиллалаа. Мөн хорооны засаг даргаас баталсан хуваарийн дагуу вакцинада хамрагдаагүй 1250 иргэд рүү утсаар холбогдон III тунд хамрагдахын ач холбогдлын талаар зөвлөмж өгч уриалж ажиллалаа.

- ХУД-ийн 18-р хорооны 1465 иргэд дархлаажуулалтын нэмэлт III тунд, 852 иргэн IV тунд хамрагдсан байна. Тус хороо нь **73.5 %**- тай III тунд хамрагдсан байна.
- ХУД-ийн 21-р хорооны 6165 иргэд дархлаажуулалтын нэмэлт III тунд, 203 иргэн IV тунд хамрагдсан байна. Тус хороо нь **76 %**- тай III тунд хамрагдсан байна.

№	Аж ахуйн нэгж байгууллага хорооны дугаар	Нийт иргэн/ажилчдын тоо/	3-р тунд хамрагдсан хүний тоо	Хамрагдаагүй хүний тоо	3-р тунд хамрагдаагүй шалтгаан			3-р тунд хамрагдах хүний тоо	Явуулын баг авах захиалга	4-р тунд хамрагдсан хүний тоо
					Хоног болоогүй	Эрүүл мэндийн	Татгалзсан			
1	<b>Хан-Уул дүүргийн 18-р хороо</b>	1,992	1,465	527	31	40	22	424	байхгүй	852
2	<b>Хан-Уул дүүргийн 21-р хороо</b>	8,108	6,165	1,943	31	40	205	1,667	байхгүй	203





Сайжруулсан түлшний хэрэглээг эрчимжүүлэх, хяналт тавих зорилгоор ХУД-ийн 21-р хороонд ажиллалаа. Тус хороонд ажиллах төлөвлөгөөний дагуу 7-р хэсгийн ахлагч Г.Мөнхжаргал, 5-р хэсгийн ахлагч Д.Нандин нартай тус хорооны нутаг дэвсгэрт амьдардаг


давхардсан тоогоор 150 айл өрхөөр орж, сайжруулсан түлшний хэрэглээнд хяналт тавьж ажиллалаа. ХУД-ийн 21 дүгээр хороо нь түлшний цэггүй, 54 яндантай айл өрхтэй бөгөөд тус хороонд ихэвчлэн барилгын манаач хийдэг айл өрхүүд зонхилдог байна. Түүхий нүүрс илрүүлсэн зөрчилгүй, бүх айлууд сайжруулсан түлшээ хэрэглэж хэвшсэн байлаа. Манай байгууллага айл өрхүүдээр хяналт тавьж ажиллахдаа шаардлагатай зөвлөмжүүдийг тухай бүр өгч ажиллаж, угаарын хий мэдрэгчтэй айл өрхийн тоог нэмэгдүүлэхэд анхаарч ажиллалаа. Тус хороонд угаарын хий мэдрэгчтэй 5 айл байсан бөгөөд 9 айлыг угаарын хий мэдрэгчтэй болгож, нийт 14 айл болсон байна. Эко хотхоны айл өрхүүд халаалтандаа цахилгаан халаагуур ашигладаг бөгөөд камен зуухны түлшинд “Хурх” ХХК-ны үртсэн шахмал түлшийг ашигладаг байна. Ажиллах хугацаанд ямар нэгэн зөрчилгүй илрээгүй, тайван ажиллалаа.






**5.2.4.** Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III”-ын холбогдох заалтын хэрэгжилтийг хангах, Төрийн албан хэргийг 2025 оноос кирилл болон монгол бичгээр хөтлөн явуулах, цаашид бүх нийтээр монгол бичигт шилжихэд албан хаагчдаа монгол бичгийн сургалтад хамруулах, хэрэглээний орчин нөхцлийг бүрдүүлж бэлтгэлийг хангах зорилгоор дараах ажлуудыг хэрэгжүүлж ажиллаж байна:

1. Байгууллагын нийт ажилтан албан хаагчдын ажлын үнэмлэхийг Монгол бичиг, Англи хэл, Кириллээр бичиж шинэчилж ажиллалаа.
2. Монгол бичгийн сургалтын төлөвлөгөөний 2021 онд гаргасан хуваарийн дагуу 2022 онд хийж хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлуудаа дэс дараатай хэрэгжүүлж ажиллаж байна.
3. Ажлын байранд Монгол бичгийн сургалтыг эхний ээлжинд Захиргааны албан хаагчдыг хамруулахаар 7 хоног бүрийн I, III, V өдрийн 08.30-09.30 цагийн хооронд сургалт зохион байгуулж ажиллаж байна.







**5.2.5.** Өргөө нь Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2022 оны А/08 дугаар тушаалаар Нийслэлийн нутаг дэвсгэрт нийтийн их цэвэрлэгээний ажлыг зохион байгуулах хуваарь батлагдсаны дагуу 2022 оны 04-р сарын 23-ны өдрийн 10:00-18:00 цагийн хооронд “Бүх нийтийн хаврын их цэвэрлэгээ”-нд нэгдэж, гадна орчныхоо 50 метр хүртэлх зам, талбай, орчныхоо хог хаягдлыг цэвэрлэн, барилгын хана, туурга, үүд, цонх, хаяг, самбар, хар шал, шат, гадна талбайг угааж цэвэрлэн, цэвэр цэмцгэр орчныг бүрдүүлж ажиллалаа. Мөн барилгын дотор хэсгийн цонх, шил, хана, хаалга, төв хаалганы шилэн гоёл, суурилагдсан гэрлийн бүрхүүлүүд, их танхимын сандал, хивсэнцэр, тайзны шал, үүдний хэсэг, ажиллагсадын үүдний шилэн хаалга зэргийг цэвэрлэж ажиллалаа. “Их хотоо эзний сэтгэлээр цэвэрлэе” уриан дор зохион байгуулагдсан бүх нийтийн хаврын их цэвэрлэгээний ажилд байгууллагын нийт ажиллагсад идэвхи зүтгэлтэй хамрагдлаа.







**5.2.6.** Өргөө нь Монгол Улсын Ойн тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлигийн хүрээнд хэрэгжүүлэх “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Ногоон хот–Иргэний оролцоо” хаврын мод тарих аянд нэгдэж, ХУД-ийн 14 дүгээр хороо Айдсын амны 7 га талбайд мод тарих байршилд албан хаагч бүр 3 ширхэг мод тарих хуваарийн дагуу 2022 оны 05 дугаар сарын 15-ны өдөр байгууллагаас 17 ажилтан албан хаагч хамрагдаж, 51 нүхэнд (улиас 15 ширхэг, хайлаас 92 ширхэг) нийт 107 ширхэг мод тарьж, ой мод, усны нөөцийг хамгаалах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд хамт олноороо идэвхи зүтгэлтэй хамтран ажиллалаа.




**5.2.7.** Сүхбаатар дүүргийн Засаг даргын тамгын газраас ирүүлсэн 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн №2/1939 дугаар албан бичгийн хэрэгжилтийг хангаж, хог хаягдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.10 дахь хэсэгт заасны дагуу 2022 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр “Бүх нийтийн их цэвэрлэгээ” зохион байгуулж, байгууллагын 50 метр хүртэлх талбайн цас мөсийг цэвэрлэж, аюулгүй цэвэр цэмцгэр байдлыг бүрдүүлж, байгууллагын нийт ажиллагсад идэвхи зүтгэлтэй хамрагдлаа.



**5.2.8.** Нийслэлийн Засаг Даргын Тамгын газраас ирүүлсэн 2022 оны 03/5998 тоот албан бичгийн хэрэгжилтийг хангаж, Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх “Нандин бүхнээ хамгаалъя – Өөрийгөө, гэр бүлээ, орчин тойрноо” аянд Нийслэлийн Соёлын Төв Өргөөний хамт олон нэгдэж, нутгийн захиргааны байгууллагын удирдлагын нэгдсэн систем болон байгууллагын пейж хуудсанд постер бэлтгэн нийтэлж, албан хаагчид, иргэд олон нийтийг уриалж нэгдлээ.



**5.2.9.** Нийслэлийн Засаг Даргын Тамгын газраас ирүүлсэн 2022 оны 02-03/6233 тоот албан бичгийн хэрэгжилтийг хангаж, Монгол улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 43 дугаар зарлигт Согтууруулах ундааны зохисгүй хэрэглээнээс үүдэлтэй сөрөг нөлөөлийг бууруулах, хорт зуршлаас ангид шинэ соёлыг төлөвшүүлж сурталчилахаар “Намайг алгас” нөлөөлийн аянд Нийслэлийн Соёлын Төв Өргөөний хамт олон нэгдэж, байгууллагын цахим хуудас, пейж хуудсанд зөв хандлага, зөв сонголт, шинэ соёлыг төлөвшүүлэхээр шторк бэлтгэн нийтэлж, нийгэмд сайн сайхныг сурталчилахаар уриалж ажиллалаа.



**5.2.10.** Нийслэл Засаг даргын 2022 оны “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” А/1357 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд шинээр байгуулагдсан Чингэлтэй дүүргийн 23 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлаж буй сайжруулсан шахмал түлшний борлуулалтын 5 цэгт 2022 оны 11 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн түлшний ханган нийлүүлэлт болон борлуулалтад хяналт тавьж ажиллаж байна. 17 дугаар хорооны хэсгийн ахлагчид болон 23 дугаар хорооны хэсгийн ахлагч Б.Үзмээтэй

өргөөний нийт албан хаагчид түлшний цэгийн хуваарийн дагуу хяналт тавин ажиллаж байна. Сайжруулсан шахмал түлшний борлуулалтын цэгүүдийн хоногийн мэдээг цаг хугацаанд нь Чингэлтэй Дүүргийн Тамгын газрын Агаар орчны бохирдолтой тэмцэх газрын тасгийн дарга Буянчимэгт хүргүүлэн ажиллаж байна.



ЗӨВШӨӨРСӨН:

ЗАХИРАЛ

Д.АРИУНБААТАР

НЭГТГЭН ГАРГАСАН:

ХҮНИЙ НӨӨЦИЙН АЖИЛТАН

Э.ЭНХЖАРГАЛ

